

Гөөнийгийн Лхүндэв^{1,✉}, Цэрэндоржийн Болорбат¹,
Дашзэвэгийн Базаргүр¹

¹Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Хэрлэн голын баруун эргээс шинээр илрүүлсэн неолитын дурсгал

Товчлол: Монгол орны нутаг дэвсгэрээс эдүгээ чулуун зэвсгийн хуучин, дунд, шинэ үед холбогдох 1000 гаруй дурсгалт газар илрүүлж, бүртгэн баримтжуулаад байна. Дурсгалт газрууд нь ихэвчлэн том, жижиг голын хөндий дагуу, нөмөр нөөлөг газарт эсвэл эртний нуур цөөрөм, хуурай сайрын эргэн тойрноос илэрч олддог байршил зүйн нийтлэг байдал ажиглагддаг. Үүнээс ил усны дэргэдэх элсэн тарамцаг, манхны ойр орчмоос гол төлөв мөстлөгийн дараах үед холбогдох чулуун зэвсгийн олдвор, шавар савны хагархай газрын хөрсөн дээр тархсан байдалтай, ил суурингийн хэлбэрээр орших онцлог хэв шинж бий. Ийм дурсгалт газраас дээр дурдсан олдворуудаас гадна хүн, амьтны яс, элдэв янзын сувс, хүрэл, ширэм, төмрөөр хийсэн олон төрлийн олдвор илэрч олоход нь түгээмэл байдаг. Тодорхой нэг газарт түүхийн өөр өөр цаг үед холбогдох олдворууд холилдон байх нь Монгол орны уур амьсгалын өвөрмөц нөхцөл хийгээд тухайн дурсгал агуулж буй газрын гадаргын онцлогтой холбоотой нь дамжиггүй юм. Ил усны дэргэдэх элсэн тарамцаг, манхан орчмын газар нь мөстлөгийн дараах үеийн ан гөрөө болон түүвэрлэх аж ахуй эрхлэгчдийн хувьд амьдрахад таатай орчин бүрдсэн газрын нэг байсан төдийгүй тухайн үеийн хүмүүсийн ахуй амьдралын дүр зураглалыг сэргээн босгох үндэс суурийн нэг нь болдог. Ийм дурсгалт газруудын нэг бол Хэнтий нуруунаас эх авч Монгол орны зүүн бүс нутгийг дамжин урсах Хэрлэн голын сав нутаг юм.

Бид энэхүү өгүүлэлд Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг, Хэрлэн голын баруун эрэгт орших Халгайтын булангаас шинээр илрүүлсэн дурсгалт газраас түүвэрлэн цуглуулсан олдвор, хэрэглэгдэхүүн (чулуун эдлэл 133, ваар савны хагархай 20 гаруй)-д хийсэн дүн шинжилгээний үр дүнг танилцуулж байна. Чулуун зэвсгийн олдвор нь бүхэлдээ неолитын хэв шинжийг агуулжээ. Анхдагч цуулалт нь тайрдсан болон шаантган үлдэц хийхэд зориулагдсан бэлдэц, үлдцээр илэрхийлэгдэнэ. Багаж зэвсгийн ихэнх хувийг жижиг хэмжээтэй төрөл бүрийн хусуур зэвсэг бүрдүүлэх бол зэв, зуулга ир, ялтсан зэв, холтослуур, цоолтуур, шөвөг, ооль, хосолмол зэвсэг, иртэй ялтас, иртэй цуулдас, самбар болон нүдүүр чулуу зэрэг неолитын үеийг бүрэн төлөөлөх эдлэл байгааг тодорхойлов.

Түлхүүр үг: Халгайтын булан, шинэ чулуун зэвсэг, үлдэц, зэвсэг, ваар савны хагархай

Lkhundev Guunii^{1,✉}, Bolorbat Tserendorj¹,
Bazargur Dashzeveg¹

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace Avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

A Newly discovered neolithic site from the south bank of the Kherlen river

Summary. More than 1,000 sites related to the Paleolithic, Mesolithic, and Neolithic periods have been discovered and recorded in the territory of Mongolia. These sites are principally found along large and small river valleys, in sheltered areas, near sand dunes, or around ancient lakes and other bodies of water. The artifacts from most of these sites consist of stone tools and pottery shards. These assemblages are often found on the surface in the form of in situ settlements, with most being considered to be Holocene in age. In addition to the above-mentioned artifacts, it is common to find many types of artifacts made of beads, bronze, cast iron, and iron, as well as human and animal bones. The mixing of related artifacts from different periods of history in a certain place is undoubtedly related to the unique climatic conditions of Mongolia that hinder sedimentation or cause erosion, resulting in the formation of these archaeological palimpsests. Archaeological survey and excavation suggest that the areas around prehistoric sand dunes near lakes and rivers seems to have been a favorable environment for hunter-gatherer activities in the region during the Holocene. This association represents a critical opportunity for reconstructing the past lifeways of these ancient peoples. One of these sites lies in the basin of Kherlen River, which originates from the Khentii Mountains and flows through the eastern region of Mongolia. Here we have collected a total of 153 artifacts from an area called Khalgaityn Bulan located on the south bank of the Kherlen River in Khulunbuir township, Dornod Province. Among the finds there are 12 cores, including 6 preforms, 5 narrow-faced cores, 2 wedge-shaped cores, 3 cone-shaped cores, and 1 micro-core. The collection of 85 tools consists mainly of various small scrapers, while there are tools that are fully representative of the Neolithic period, such as arrowheads, fragments of chipped adze, beveled points, notched tools, borers, retouched blades, grinding slabs, and handstones. However, blades make up 78.8% of the lithic production activities preserved at the site. Based on the primary knapping method, the type of tools, the size and the production of industry, the artifact assemblage from Khalgaityn Bulan is considered to be related to a developed stage of the Neolithic period.

Key words: *Khalgaityn Bulan, Neolithic period, core, tool, pottery shards*

Хэрлэн голын сав дагуух

чулуун зэвсгийн дурсгалт газрууд

1948 оноос ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн С.В.Киселевийн удирдлага дор Монгол-Зөвлөлтийн түүх-угсаатны зүйн хамтарсан экспедици байгуулагдаж Монголын археологийн дурсгалыг өргөн хүрээнд судлан шинжлэх ажил эхэлсэн [Дорж, 1971: 13] байдаг.

1949 онд тус экспедицийн бүрэлдэхүүнд чулуун зэвсгийн дурсгал судлах тусгай анги зохион байгуулагдаж, академич А.П.Окладниковын удирдлага дор зүүн тийш Чойбалсан хүртэл Хэрлэн голын хөндийг судалж, дараа нь Халх гол, Тамсагбулаг, Хэрээ уул [Деревянко и др., 1990: 41-42] хүртэл хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэсэн байдаг. Энэ нь Хэрлэн голын сав дагуу хийгдсэн археологийн анхны судалгааны ажил болж тэмдэглэгдэн үлджээ.

Үүний хойно 1967 оноос Чулуун зэвсгийн дурсгал судлах анги дахин зүүн хязгаарт ажиллаж Дорнод аймгийн нутгаас Өлзийт нуур, Хүйтэн булгийн палеолитын дурсгал, Халх голын савд Хэрээ уулын мезолитын суурин, Тамсагбулаг, Хэрлэнгийн эрэг орчмоос неолитын үе [Деревянко, Окладников. 1969: 141-156]-ийн газар сууц, булш оршуулгын дурсгал илрүүлж, малтан шинжилсэн нь Монголын чулуун зэвсгийн судалгааны түүхэн дэх томоохон ололт амжилтын нэг байв.

Эдгээрээс гадна Хэрлэн голын эрэг дагуу орших

Овоотын газар сууц, Зүүн Өлзийт уулын булш, Баруун Өлзийт, Хэрлэн-9, Мөнх толгойн суурин [Дорж, 1971: 23-36; Окладников, 1950: 160-162], Норовлин уулын булш [Совместный отчет., 1977: 44-50]-ны олон төрлийн олдвор нь тэнд оршин суугчдын эрхлэх аж ахуй, зан заншил, шүтлэг бишрэл, нийгмийн байгуулал, угсаа соёл зэрэг олон асуудлыг шинжлэх ухааны үүднээс баттай тогтооход үнэт эх хэрэглэгдэхүүн болж байна.

Дээрх судалгаа шинжилгээний ажлаас хойш Хэрлэн голын сав дагуух газарт чулуун зэвсгийн томоохон хэмжээний хайгуул болон малтлага судалгаа 1990 он хүртэл хийгдээгүй ажээ. Харин 1990 оноос хойш тус голын эрэг дагуух газраас гадаад улс оронтой хамтарсан болон дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн археологийн судалгааны ажлын явцад хэд хэдэн дурсгалт газруудыг шинээр илрүүлэн олсон байна.

1990-1993 онд ажилласан Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн судлаачид Хэрлэн голын эхэн болон дунд урсгалын баруун эргийн Ухаа толгой, Долоон чулуут, Уу булан, Номгон уул, Зорголын шар хад, Цагаан нуур, Хустын булаг зэрэг газраас ихэнхдээ палеолитын хэв шинж бүхий олдворт хэд хэдэн дурсгалт газар [Цэвээндорж нар., 1990] шинээр илрүүлсэн бол 2009 онд “Дорнод Монгол” төслийн судлаачид Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Майхан толгой, Дорнод аймгийн Булган сумын нутаг

Норовлин уул [Наваан нар., 2009: 15-16], 2011 онд Монгол-Японы хамтарсан “Монгол хүн” төслийн судлаачид Дорнод аймгийн нутаг Баруун, Зүүн Өлзийт болон Норовлин уул [Монгол-Японы., 2011: 2-33], 2016 онд Монгол-Америкийн хамтарсан “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн судлаачид Хэрлэн голын хойд эрэг Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг Батхаан уулын Ханан, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Баян хошуу [Одсүрэн нар., 2017: 32-33] зэрэг газраас неолитын үеийн олон төрлийн чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цуглуулжээ. Хамгийн сүүлд 2018, 2021 онд бидний өгүүлэн буй дурсгалт газар ШУТИС-ийн БУХС болон Археологийн хүрээлэнгийн судлаачид очиж түүвэр байдлаар олдвор хэрэглэгдэхүүний цуглуулгыг бүрдүүлсэн юм. Түүвэр цуглуулгын зарим нь өдгөө ШУТИС-ийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа болно.

Хэрлэн гол

Их Хэнтийн нурууны өвөр хажуугаас эх авсан Богдын гол, Цагаан голын бэлчрээс доош Хэрлэн хэмээн нэрлэнэ. Хэрлэн гол нь эх хэсэгтээ өмнө зүг чиглэн урсах бөгөөд аажмаар зүүн тийш эргэж, улмаар хилийн цаана БНХАУ-ын нутагт орших Далай нуурт цутгадаг. Голын нийт урт 1264 км бөгөөд улсын хил хүртэл 1090 км үргэлжлэх ажээ. Ус хураах талбай нь 116,455 км². Голын гольдрол нь ихээхэн тахирлан урсах ба зарим газраа олон салаа үүсгэдэг [Цэгмид, 1969; 153-156] байна.

Судалгааны арга зүй

Бид дурсгалт газрын байршил болон олдвор хэрэглэгдэхүүний тархалтын хүрээг Global Positioning Systems (GPS) eTrex20 Garmin багаж ашиглан солбицлыг WGS84 Lat/Lon hddd'mm'ss.s" өгөгдлөөр тогтоосон. Тухайн газрын гадарга дээр буй чулуун зэвсгийн олдворуудаас бэлдэц, үлдэц, багаж зэвсгийн холбогдолтой эдлэл, залтас болон ялтас, мөн ваар савны хагархай зэргийг сонголтын зарчмаар түүвэрлэж цуглуулгыг бүрдүүлсэн.

Түүвэр цуглуулгын анхдагч цуулалт, хоёрдогч боловсруулалт болон цуулдасны үйлдвэрлэлийг ангилан ялгах зэрэг чулуун зэвсгийн төрөл зүйн уламжлалт арга зүйг баримтлан тодорхойлолтыг хийв.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Чулуун зэвсэг, самбар чулуу, нүдүүр чулууны хугархай, ваар савны хагархай зэрэг олдворуудыг Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг Хэрлэн голын урсгалын баруун эрэг, нутгийн иргэд Халгайтын булан (зураг 1) хэмээн нэрлэх газарт хойш налуу элсэрхэг хотос хонхор бүхий газарт гурван удаа очиж түүвэрлэн цуглуулсан

юм. Олдворуудын тодорхойлолт. Чулуун зэвсэг үйлдвэрлэх арга ажиллагааны үндсэн шинж байдлыг тодорхойлдог гурван хүчин зүйлийн дагуу олдворуудаа ангилж (хүснэгт 1), онцлог хийгээд төлөөлөл болохуйц зарим олдворыг дэлгэрэнгүй тодорхойлов. Анхдагч цуулалттай холбоотой эдлэлд бэлдэц, үлдэц, цуулалтын оромтой хагархай, техникийн цуулдас тус тус хамаарна.

Бэлдэц – 6 ш. Эдгээрээс гурав нь шаантган үлдцийн бэлдэц юм. Эхнийх нь жижиг хэмжээтэй бөгөөд цохилтын талбайг хөндлөн цуулалтуудаар тэгш бэлтгэсэн байна. Гүдгэр хэлбэртэй нэг хажуу талыг хоёр захаас нь төв рүү чиглэсэн хөндлөн цуулалтуудаар зассан бол төв хэсэгт нь чулууны өнгөн бүрхүүл хэвээр үлджээ. Нөгөө хажуу талыг цохилтын талбай талаас тууш цуулалтаар ялимгүй хотгор болгон зассан байна. Суурь хэсгийг нарийвчлан засалгүй орхижээ (зураг 2. 1). Хоёр дахь бэлдэц нь урт зууван хэлбэртэй. Бэлдцийн нэг хажуу талыг бүхэлд нь захаас төв рүү чиглэсэн хөндлөн цуулалтаар хавтгайлсан байна. Эсрэг гүдгэр талын хагасыг зөвхөн нэг талаас нь хөндлөн цуулалтаар нийт гадаргууны 2/3-ыг зассан бол үлдсэн талын хагасыг засах замаар гүдгэр нуруу үүсгэжээ. Өргөн талд нь нэг цохилтоор цохилтын талбай бэлтгэх оролдлого хийсэн байх ба суурь хэсгийг шовхолж зассан байна (зураг 2. 3). Гурав дахь бэлдцийг ихэд нямбай засаж бэлтгэжээ. Хоёр хажуу талыг эхлээд тууш цуулалтаар, дараа нь хоёр захаас төв рүү чиглэсэн зэрэгцээ хөндлөн цуулалтуудаар гүдгэр хэлбэрт оруулан зассан байна. Үүний дараа цуулалтын гадаргуу болох өргөн хэсгийг нарийвчлан засалгүй орхисон бол эсрэг орших талыг дахин хөндлөн зэрэгцээ олон цуулалтаар жигд засаж хурц ирмэг үүсгэжээ. Бэлдцийн өргөн нэг талыг хөндлөн байдлаар олонтаа холтчих замаар бага зэрэг налуу цохилтын талбай бэлтгэсэн бол суурь хэсгийг засалгүй орхисон байна (зураг 2. 5). Дараагийн төрөл нь тайрдсан үлдцийн бэлдэц юм. Бэлдцийн гүдгэрдүү цохилтын талбайг хөндлөн цуулалтаар бэлтгэжээ. Цуулалтын гадаргууг хөндлөн цуулалтаар тэгш бэлтгэсэн бол эсрэг талыг нэг цуулалтаар мөн ташуу маягтай болгон зассан байна. Бэлдцийн нэг хажуу талыг нь цохилтын талбай талаас тууш цуулалтаар, нөгөө хажуу талыг сөргүүлсэн хөндлөн цуулалтаар нимгэлэн зассан байх ажээ (зураг 2. 4).

Гурав дахь төрлийн бэлдэц нь залтас цуулах зориулалттай. Бэлдцийн хоёр гүдгэр хажууг захаас төв рүү чиглэсэн хөндлөн цуулалтуудаар зассан байна. Харин цохилтын талбайг бэлтгэлгүй орхижээ (зураг 2. 6).

Үлдсэн нэг бэлдэц нь суурь хэсэг рүүгээ шувтан дөрвөлжиндүү хэлбэртэй. Цохилтын талбайг

Хүснэгт-1. Чулуун зэвсгийн төрөл зүйлийн ангилал

Олворуудын төрөл зүйл	Тоо
Анхдагч цуулалт	22
Бэлдэц	6
Үлдэц	12
- шовх	3
- шаантаг хэлбэрийн	2
- тайрдсан	5
- цилиндр	1
- бичил	1
Цуулалтын оромтой хагархай	1
Техникийн цуулдас	3
Багаж зэвсгийн төрөл зүйл	59
Зэв	1
Ялтсан зэв	3
Хусуур	26
- төгсгөл	16
- төгсгөл болон хажуугийн	3
- давхар иртэй	1
- дугуй	2
- ирмэгийн 2/3-ыг ирлэсэн	1
- ирмэгийн 3/4-ыг ирлэсэн	3
Хосолмол зэвсэг	3
Чулуун сүх	2
Хянгар	1
Зуулга ир	3
Холтослуур	2
Цоолтуур	2
Шөвөг	1
Ооль (хугархай)	1
Хутга (хугархай)	1
Иртэй цуулдас	5
Иртэй ялтас	5
Самбар чулуу	2
Нүдүүр чулуу	1
Цуулдасны үйлдвэрлэл	52
Ялтас	41
Залтас	7
Цуулдас	4
Нийт	133

налуу бэлтгээд ямар нэг цуулалт хийгээгүй ажээ. Уг бэлдэц нь чулууны бүтэц, хатуулаг шинж чанар, мөхлөг зэргээс шалтгаалан ихэд өгөршиж элэгдсэн байна.

Үлдэц – 12 ш. Эдгээрийг шовх, тайрдсан, цилиндр, шаантаг хэлбэрийн, бичил үлдэц хэмээн ангилж болох ба бүгд ялтас цуулах зориулалттай ажээ.

Шовх үлдэц гурав байгаа нь харьцангуй том хэмжээтэй юм. Эдгээр нь суурь луугаа нарийссан урт зууван хэлбэртэй бөгөөд зэрэгцээ цуулалтаар нимгэн урт ялтас салган авсан байна. Бүгд шовх суурьтай, тэгш цохилтын талбайтай ажээ. Цохилтын талбайг төв рүү чиглүүлэн холтчих замаар бэлтгэсэн байна. Мөн үлдцийн цохилтын талбайн ирмэг хөвөөг тойруулан холтчин зассан байх ажээ. Нэг үлдцийн цохилтын талбайн тал бүрээс зэрэгцүүлэн тэгш хэмт урт ялтас салган авсан байна. Үлдцийн хэмжээ 8,3x2,4x2,0 см (зураг 3. 1). Нөгөө хоёр үлдэц нь хавтгай артай. Эхнийх нь 8,4x3,5x2,5 см (зураг 3-10) бол хоёр дахь нь 7,2x2,5x1,8 см (зураг 3. 11) хэмжээтэй. Тэдгээрийн нүүр болон хоёр хажуу талаас цуулалт хийсэн байна. Тэгш хэмт олон ялтас цуулж авсан ормоос үзэхэд өргөн, урт нь харилцан адилгүй ажээ. Зарим ялтасны урт үлдцийн уртын хэмжээтэй адил бол богино нь 3,0 см байна.

Тайрдсан хэв шинжийн үлдэц тав байна. Эхний үлдцийн тэгш цохилтын талбайг холтчих замаар бэлтгэжээ. Цохилтын талбайгаас зэрэгцүүлэн тэгш хэмт уртавтар ялтас салган авсан байх ба зарим хэсэгт цуулалт хийгдээгүй чулууны өнгөн бүрхүүл хэвээр үлдсэн байна. Цуулалтын гадаргуу нь бага зэрэг гүдгэр бол эсрэг тал нь хавтгай ажээ. Харин суурь хэсгийг бага зэрэг засаж ирмэг гаргасан байна (зураг 3. 2). Хоёр дахь үлдэц нь тэгш цохилтын талбайтай байх ба суурь хэсэг нь хавтгай ажээ (зураг 3. 5). Гурав дахь үлдцийн цохилтын талбайг налуу бэлтгэсэн бол суурь нь шовх (зураг 3. 8). Энэхүү хоёр үлдцийн цохилтын талбайн бүх талаас нь жижиг ялтас цуулж авсан байна. Үлдсэн хоёр үлдэц нь нимгэн артай хавтгай хэлбэртэй. Нэг үлдцийн арагш налсан цохилтын талбайг хоёр тууш цуулалтаар бэлтгэсэн байх ба суурь нь шовх ажээ. Түүний гүдгэрдүү цуулалтын гадаргуугаас зэрэгцүүлэн тэгш хэмт ялтас хэд хэдийг салган авсан ором үлдсэн байна (зураг 3. 9).

Дараагийн үлдэц нь цилиндр хэлбэртэй бөгөөд эсрэг орших дугуй хэлбэртэй хоёр цохилтын талбайтай ажээ. Суурь хэсгийг тайрах замаар нэг цохилтын талбайг хожим бэлтгэсэн бололтой. Анх бэлтгэсэн цохилтын талбайг ашиглан бүх талд нь цуулалт хийжээ (зураг 3. 3).

Шаантаг хэлбэрийн үлдэц хоёр бий. Эхний үлдэц нь цохилтын хоёр талбайтай. Цохилтын

талбайг хөндлөн цуулалтаар бага зэрэг урагш налуу байдлаар бэлтгэсэн байна. Цуулалтын гадаргуугаас зэрэгцээ цуулалтаар нимгэн урт ялтас олныг цуулж авсан бол ар талыг хөндлөн цуулалтаар хоёр талаас нь жигд зассан нь долгио маягийн хурц ирмэг үүсгэжээ. Энэ нь шаантган үлдцийн цуулалтын гадаргууны эсрэг талыг бэлтгэх арга ажиллагаатай тун төстэй. Магадгүй, уг үлдцийг ашиглаж дууссаны дараа суурь хэсгийг тасдаж цохилтын хоёр дахь талбайг бэлтгэсэн байх боломжтой юм (зураг 3. 6). Нөгөө үлдэц нь цохилтын нэг талбайтай ба төв рүү чиглүүлэн олон удаа холтчих замаар бэлтгэжээ. Цуулалтын гадаргуудаа зэрэгцээ байдлаар харилцан адилгүй өргөнтэй олон ялтас салган авсан оромтой. Цуулалтын гадаргуун эсрэг талыг хоёр талаас нь хөндлөн цуулалтаар хурцлан зассан байна. Харин суурь хэсгийг янзлалгүй орхижээ (зураг 3. 4).

Хамгийн сүүлийнх нь цохилтын нэг талбайтай бичил үлдэц юм. Энэ нь доошоо шувтан дөрвөлжиндүү хэлбэртэй. Цохилтын талбай нь хотгор бөгөөд ирмэг хэсгээрээ дэрэвгэр. Үлдцийн цохилтын талбайг дахин засах явцад ташуу хагарч налуу мэт болжээ. Суурь хэсэг нь тэгш бөгөөд цуулалтын гадаргуугаас зэрэгцээ цуулалтаар олон богино ялтас авсан оромтой. Цуулалтын гадаргууны хоёр хажуу, ар талыг хөндлөн цуулалтуудаар зассан байна (зураг 3. 7).

Цуулалтын оромтой хагархай – 1 ш.

Дөрвөлжиндүү хэлбэртэй уг эдлэлд цохилтын талбай бэлтгээгүй ажээ. Тууш нэг захаас хөндлөн цуулалтуудаар засах оролдлого хийсэн ба суурь хэсгийг хоёр талаас нь тууш цуулах замаар ирмэг гаргасан байна (зураг 2. 2).

Техникийн цуулдас – 3 ш. Эхнийх нь тэгш бус хэмт богино гурвалжин цуулдас, нөгөө хоёр нь өндөр нуруутай хажуугийн цуулдас ажээ. Нэг нь харьцангуй урт болно. Эдгээр цуулдас үлдцийн хажууг засах явцад гарчээ.

Багаж зэвсгийн төрөлд зэв, ялтсан зэв, зуулга ир, хусуур, хянгар, чулуун сүх, хосолмол зэвсэг, цоолтуур, хүнхэр зэвсэг, шөвөг, ооль, хутга, самбар чулуу, нүдүүр чулуу, иртэй ялтас болон иртэй цуулдас зэрэг багтана.

Зэв – 1 ш. Тэгш суурьтай, гурвалжин хэлбэртэй. Зэвийг ар, өвөр талаас нь хөндлөн холтчих байдлаар засаж нимгэлжээ. Дараа нь ирмэг хэсгийг захын жижиг ирээр ирлэсэн байна. Зэвний торгон үзүүр хэсгийг төдий л нямбайлж засалгүй орхижээ. Харин суурь хэсгийг мөн хоёр талаас нь тууш холтчих байдлаар нимгэлэн засаж мөсөнд суулгахаар тэгшилсэн байна (зураг 4. 1).

Ялтсан зэв – 3 ш. Эхний хоёр зэвийг гурван талт жижиг ялтас ашиглан хийжээ. Хоёуланд нь ар талын нэг үзүүрийг хоёр захаас нь жижгээр жигд холтчин ирлэж гурвалжин хэлбэрийн хурц үзүүр

гаргасан байна (зураг 4. 2). Харин нэг зэвний нүүрэн талын гурвалжин хэсгийн нэг захыг жигд холтчин ирлэжээ (зураг 4. 3). Энэхүү хоёр зэвний тууш хоёр захаар тохиолдлын ир ажиглагдана. Гурав дахь зэвийг хоёр талт бичил ялтас ашиглан хийжээ. Зэвсэг хийх арга ажиллагаа нь эхний зэвүүдтэй адил ба үзүүр хэсгээрээ хугарсан байна. Уг зэвийг ар талын хоёр захыг үзүүр хэсгээс суурь хүртэл нь жигд нямбай ирлэжээ. Суурь хэсэг нь хугарсан тул хэрхэн зассан болохыг тодорхойлох боломжгүй (зураг 4. 4).

Зуулга ир – 3 ш. Хоёр болон гурван талт жижиг ялтасны ар талын хоёр захыг нэлэнхүйд нь жижиг ирээр жигд налуулан ирлэжээ. Нэг зуулга ир зэвсгийг эхлээд томоор хэлтлэн нимгэлээд дараа нь жижгээр холтчин зассан нь мэдэгдэнэ. Эдгээр зэвсгийг ялтасны дунд хэсэг (зураг 4. 6), үзүүр хэсэг (зураг 4. 7) болон цохилтын товгор бүхий дээд хэсэг (зураг 4. 5)-ийг ашиглан тус тус хийжээ. Гурав дахь зуулга ир зэвсгийн цохилтын товгорын эсрэг орших нүүрэн талын дээд хэсгийг нэлэнхүйд нь холтчин засаж нимгэлсэн байна.

Хосолмол зэвсэг – 3 ш. Эхний зэвсгийг анхдагч залтас ашиглан хийсэн байх ба нэг тууш талыг жижиг босоо ирээр ирлэжээ. Харин хөндлөн нэг талыг дугуйруулан гол хэсэгт шовх үзүүр гаргаж ирлэсэн нь хугарсан байна. Шовх үзүүр хэсэг нь зэвсгийн гол тэнхлэгтэй харьцуулахад ташуу байрлалтай ажээ. Уг эдлэл нь хажуугийн хусуур болон цоолтуур зэвсэг хосолсон хэв шинжтэй (зураг 4. 8). Дараагийн зэвсгийг тэгш хэмт гурван талт ялтас ашиглан хийжээ. Ялтасны нэг үзүүр хэсгийг холтчин босоо байдлаар ирлэсэн бол ар, өвөр талын эсрэг байрлах тууш нэг захыг жижгээр холтчин ирлээд гүйцээлгүй дутуу орхисон байна. Уг ялтасны эсрэг байрлах нөгөө үзүүрийн ялимгүй хажуу талд нэг цуулалтаар хүнхэр ховил гаргажээ. Энэ эдлэл нь төгсгөл хусуур болон зурваслуур хосолсон хэв шинжтэй. Хэрэв тууш захын ирийг бүрэн гаргасан бол зуулга ир зэвсгийн хосолмол ч байж болохоор юм (зураг 4. 9). Сүүлийн зэвсгийг хоёр талт өргөн ялтас ашиглан хийжээ. Ялтасны тууш хоёр захыг нүүрэн талаас нь жигд холтчин ир гаргасан байна. Үзүүр хэсэг нь хугарсан тул дахин ташуу цуулалтаар засаж сийлүүрийн ир гаргасан ажээ. Энэ эдлэл нь давхар иртэй ялтас болон сийлүүр хосолсон хэв шинжтэй (зураг 4. 10).

Хянгар – 1 ш. Хөндлөн огтлолоороо гурвалжин хэлбэртэй нимгэвтэр цуулдас ашиглан хийсэн байна. Цуулдасны нүүрэн талын дугуйвтар ирмэг хэсгийг жижиг ирээр жигд бөгөөд тасралтгүй ирлэжээ. Уг цуулдасны үзүүр хэсгийн ташуу байдал нь гарт барихад нэн тохиромжтой тул хянгар зэвсэг болгон ирлэсэн байна (зураг 4. 12).

Цоолтуур – 2 ш. Эхний зэвсгийг чулуу цуулах явцад гарсан хагархайн тохиромжтой хэлбэрийг ашиглан хийсэн байна. Суурь хэсгийг хоёр талаас нь хөндлөн зэрэгцээ цуулалтаар нимгэлжээ. Зэвсгийн их биеийг нэг талаас нь зэрэгцээ хоёр хөндлөн цуулалтаар нимгэлсэн бол үзүүр хэсэгт тууш цуулалт хийж зассан ором мэдэгдэнэ. Цоолтуурын үзүүр нь хугарсан бол суурь хэсэг нь гарт барихад нэн тохиромжтой хавтгай хэлбэртэй (зураг 4. 11). Дараагийн зэвсгийг хөндлөн огтлолоороо гурвалжин хэлбэртэй цуулдасны жижиг хагархайгаар хийжээ. Нарийн үзүүр хэсгийг нүүрэн талаас нь холтчин хурцалж шовх үзүүр гаргасан байна. Харин суурь хэсэг нь хавтгай бөгөөд гол хэсэгт байх товгор нуруу нь уг зэвсгийг барихад тун эвтэй болгох ажээ. Уг цуулдасны ар талын тууш хоёр захыг жигд бус холтчин ирлэсэн байна (зураг 4. 13).

Шөвөг – 1 ш. Ялтасны нэг үзүүрийг нүүр болон ар талаас нь алсаас хөндлөн холтчин цуулж бөөрөнхийвтөр болгон зассан байна. Ингэж зассан байдал ялтасны тууш захаар бүрэн үргэлжилсэн харагдах ба үзүүр нь хурц биш ажээ (зураг 4. 14).

Ооль (хугархай) – 1 ш. Уг зэвсэг нь хавтгай, зуувандуу хэлбэртэй бөгөөд үзүүр нь хугарсан байна. Тууш захыг хоёр талаас нь зэрэгцээ солбисон том цуулалтаар засаад дараа нь жижгээр холтчин засаж хурц ирмэг гаргажээ. Нэг тууш захад нь анхдагч цуулалтаас үлдсэн тэгш ирмэг байх бол нөгөө тууш захад хоёр талаас нь ээлжлэн цуулсан долгиотсон ирмэг үүссэн байна. Суурь хэсгийг ишинд суулгах зорилгоор нэг талаас нь томоор холтчин цуулсан нь хотгор хэлбэртэй болжээ (зураг 4. 15).

Хутга (хугархай) – 1 ш. Хоёр талаас нь зэрэгцээ болон эсрэг солбисон цуулалтаар нимгэлсэн байна. Улмаар нэг талынх нь хоёр ирмэгт бичил ир гаргасан нь хэрэглээний явцад нэлээд элэгдэж мөлийжээ. Хутганы үзүүр хэсэг нь дөрвөлжин хэлбэртэй ба бичил ир нь мөн л элэгдэж зарим хэсэгтээ хагарч алга болсон байдал ажиглагдана (зураг 4. 16).

Чулуун сүх – 2 ш. Эхний эдлэлийг уртавттар гонзгой чулуу ашиглан хийсэн байна. Уг эдлэлийн урт 16,7 см, зузаан нь 2,1 см бол өргөн тал нь 5,5 см, эсрэг тал нь 3,8 см ажээ. Хоёр хажуу ирмэгийг хоёр талаас нь солбиулан цуулах замаар долгио бүхий хурц ирмэгтэй болгож сайтар зассан байна. Өргөн хөндлөн ирмэгийг мөн хоёр талаас нь солбисон цуулалтаар хагас дугуй маягийн хэлбэртэй болгон засаад, ирмэгийг дагуулан жижгээр холтчин хурцалжээ. Харин эсрэг талын хөндлөн ирмэгийг хурцалж засалгүй орхисон байна (зураг 4. 17). Хоёр дахь нь гүйцэд хийгдээгүй дөрвөлжин хэлбэртэй чулуун сүх юм. Уг эдлэл нь 7,1 x 6,6 см хэмжээтэй бөгөөд 1,9 см зузаан ажээ. Нэг хавтгай

талыг засалгүй орхисон бол эсрэг хавтгай талын зах ирмэгийг хагас босоо цуулалтаар зассан байна. Нэг талын өргөн зах хэсгийг нэг хавтгай талаас нь цуулж зассан бол эсрэг талаас нь хагас босоо цуулалтаар ирлэх оролдлого хийжээ (зураг 4. 20).

Холтослуур – 2 ш. Эхнийх нь тэгш өнцөгт хэлбэртэй хагархайн өргөн бөгөөд зузаан талын нэг тууш ирмэгт гарсан алсаас налуу хотгор гадаргууг холтчин засаж хүнхийлгэсэн байна. Энэ зэвсгийн ирний эсрэг тал нь нимгэн бөгөөд гарт барихад ихэд эвтэй (зураг 4. 18). Дараагийнх нь цуулалтын оромтой үлдцийн хагархай. Тууш нэг зах нь зузаан бөгөөд түүнийг эгц босоо томоор хүнхийлгэн засаад, ирмэгийг нь жигд холтчин ирлэжээ. Харин эсрэг орших арай богино тууш захыг хагас босоо олон удаа холтчин зассан байна (зураг 4. 19).

Хусуур зэвсэг – 26 ш. Эдгээр хусуур зэвсгүүд нь ирлэлтийн байдлаараа төгсгөл, хажуугийн, давхар, бүх ирмэгийг ирлэсэн, ирмэгийн 2/3 болон 3/4-ыг ирлэсэн хэмээн ангилагдана.

Төгсгөл хусуур – 16 ш. Зургаан хусуур зэвсгийг трапец хэлбэрийн залтас ашиглан хийжээ. Залтсуудын төгсгөл, өргөн хөндлөн ирмэгийг хагас босоо хайрслал ирээр ирлэсэн байна. Эдгээрийн нэгийг ар талаас нь бусад эдлэлийг нүүрэн талаас ирлэжээ (зураг 5. 4; 5; 11; 12; 15; 18). Нарийн ялтсаар хийсэн зургаан эдлэлийн хөндлөн байрлах төгсгөл ирмэгийг эгц босоо болон хагас босоо хайрслал ирээр ирлэсэн нь төгсгөл хусуурын хэв шинжтэй болсон байна (зураг 5. 14). Өөр нэг хусуурыг хагас анхдагч ялтсан цуулдас ашиглан хийжээ. Цуулдасны төгсгөл хөндлөн ирмэгийг хагас босоо хайрслал ирээр ирлэсэн байна (зураг 5. 1). Гурван хусуурыг гурван талт өргөн ялтасны хугархайгаар хийсэн бөгөөд төгсгөл хөндлөн ирмэгийг эгц босоо шаталсан, хайрслал ирээр ирлэжээ (зураг 5. 7; 8; 13). W

Төгсгөл болон хажуугийн хусуур – 3 ш. Эдгээрийг зууван дугуй болон дөрвөлжиндүү хэлбэртэй залтас, хагархай ашиглан хийсэн байна. Хөндлөн байрлах өргөн нэг зах болон тууш нэг ирмэгийг хагас босоо байдлаар жижгээр холтчин ирлэжээ (зураг 5. 3; 6; 9).

Ирмэгийн 2/3-ыг ирлэсэн хусуур – 1 ш. Дугуй хэлбэртэй, барзгар гадаргуутай анхдагч залтас ашиглан хийсэн байна. Залтасны дугуй ирмэгийг дагуулан 2/3-ыг холтчих маягаар ирлэжээ (зураг 5. 16).

Ирмэгийн 3/4-ийг ирлэсэн хусуур – 3 ш. Эдгээрийн нэгийг өндөр нуруутай цуулдасны хугархай ашиглан хийсэн байна. Цуулдасны төгсгөл хөндлөн ирмэгийг налуу цуулалтаар засаад, ирмэгийг дагуулан жижгээр холтчин хурцалжээ. Хоёр хажуу ирмэгийг холтчих замаар хагас босоо хэлбэртэй болгон засаад, жижгээр

холтчин ирлэсэн байна (зураг 5. 2). Нөгөө эдлэлийг дугуйдуу хэлбэртэй залтас ашиглан хийжээ. Цохилтын товгор бүхий ирмэгээс бусад ирмэгийг хагас босоо ирээр холтчин ирлэсэн байна (зураг 5. 10). Гурав дахь нь дугуйдуу хэлбэртэй бөгөөд суурь хэсэг нь хөндлөн огтлолоороо гурвалжин, өндөр нуруутай ажээ. Хажуугийн нэг ирмэгийг нарийвчлан засалгүй зузаан хэвээр нь орхисон байна. Бусад хэсгийг ар талаас нь хагас босоо байдлаар холтчин засах маягаар ирлэжээ (зураг 5. 20).

Давхар иртэй хусуур – 1 ш. Зууван дугуй хэлбэртэй залтас ашиглан хийсэн байна. Залтасны нэг хагас дугуй, арай намхан ирмэгийг эгц босоо ирээр, эсрэг талын өндөр ирмэгийг босоо цуулалтаар засаад, жижгээр холтчин ирлэжээ (зураг 5. 17).

Дугуй хусуур – 2 ш. Эдгээрийн нэгийг зузаан залтас ашиглан хийсэн байна. Төв хэсгээрээ өндөр бөгөөд нимгэн бүх талаас нь тойруулан дугуй хэлбэрт оруулан холтчин ирлэжээ. Ирлэлтийг зарим газарт эгц босоо, хагас босоо болон налуу гурван байдлаар гүйцэтгэсэн байна. Ингэхдээ налуу ирлэсэн хэсгийг мөн ар талаас нь налуулан нимгэлж ирлэсэн байдал ажиглагдах ажээ (зураг 5. 19).

Иртэй ялтас – 5 ш. Гурав нь хоёр талдаа иртэй бол хоёр нь нэг талдаа иртэй. Дөрөв нь хоёр талт бол нэг нь гурван талт ялтас болно. Бүгд гөлгөр артай ба цохилтын талбайн үлдэгдэл нь холтлогдсон, гүдгэр, хоёр талт гэх мэт ажээ (зураг 4. 21; 5. 21; 22; 23). Эдгээрийн нэг нь тэгш хэмтэй урт ялтасны хугархай бөгөөд ар талын тууш хоёр захыг нэлэнхүйд маш жижгээр жигд ирлэсэн байна (зураг 5. 25).

Иртэй цуулдас – 5 ш. Дөрөв нь жижиг хэмжээтэй бөгөөд гурав нь гурвалжин, нэг нь дөрвөлжин хэлбэртэй ажээ. Бүгд гөлгөр артай, хоёр эдлэлд цохилтын талбайн үлдэгдэл мэдэгдэнэ. Тав дахь нь харьцангуй том бөгөөд үлдцийн цуулалтын гадаргууг засах явцад гарсан хавирган хэлбэрийн цуулдас юм. Нарийн үзүүр хэсгийг нүүрэн талаас нь тууш цуулалтаар холтчин ирлэжээ (зураг 5. 24). Цуулдасны үйлдвэрлэлд ялтас, залтас, цуулдас хамаарна.

Ялтас – 41 ш. Эдгээрийг ялтасны дээд хэсгийн хугархай 20 ш, дунд хэсгийн хугархай 19 ш, үзүүр хэсгийн хугархай 2 ш бүрдүүлнэ. Ялтасны дээд хэсгийн хугархайд ташуу, арагш налуу, гэмтсэн, тэгш болон цэгэн цохилтын талбайн ором мэдэгдэнэ. Ялтаснууд нь хоёр болон гурван талтай. Том нь 5,4x2,7x07 см бол жижиг нь 1,8x0,7x0,2 см хэмжээтэй.

Залтас – 7 ш. Зургаа нь хоёрдогч, нэг нь анхдагч залтас юм. Залтаснууд нь бүгд цуулалтын гөлгөр артай. Цохилтын талбайн үлдэгдэл гурван эдлэлд

шулуун, гурван эдлэлд гүдгэр бол үлдсэн эдлэлд тодорхойлох боломжгүй байна. Хэмжээний хувьд том нь 4,0x4,5x1,5 см бол жижиг нь 1,9x2,0x0,3 см.

Цуулдас – 4 ш. Хоёр нь хавирган цуулдас ба нэг нь үзүүр хэсэг, нөгөөх нь дунд хэсгийн хугархай. Хоёр хөндлөн огтлолоороо гурвалжин хэлбэртэй. Гурав дахь нь богино бөгөөд зузаан цуулдас юм. Дөрөв дэхь нь тэгш хэмтэй өргөн ялтсан цуулдас. Цуулалтын ар тал нь жигд гөлгөр бөмбөгөр хэлбэртэй.

Самбар чулуу – 2 ш. Эхний самбар чулуу нь трапец маягийн дөрвөлжин хэлбэртэй бөгөөд гурван хэсэг хагархайгаас бүрдэнэ (нэг хагархай хэсэг нь олодоогүй). Уг эдлэлийн урт нь 29 см, өргөн талаараа 19 см бол зузаан нь 2 см ажээ. Энэхүү самбар чулууг бор өнгийн элсэн чулуу ашиглан үйлджээ. Нэг тал он удаан жил ашиглагдсаны улмаас гол хэсгээрээ элэгдэж хотойсон байна (зураг 6. 1). Нөгөө нь самбар чулууны тал хэсэг юм. Энэ эдлэлийн өргөн нь 13,8 см, урт нь 11,5 см бол зузаан нь гол хэсгээрээ 1,5 см, гуривтай хэсгээрээ 2,5 см ажээ. Өмнөх самбар чулууг бодвол илүү нарийн ширхэгтэй хүрэн бор өнгийн элсэн чулуу ашигласан байна. Самбар чулууны адил гол хэсгээрээ элэгдэж нилээд хотойсон байх ба үүний улмаас нэг үзүүр хэсэгт ойрхон гурив мэт гүдгэр бий болжээ (зураг 6. 2).

Нүдүүр чулуу – 1 ш. Нүхтэй барзгар гадаргуутай, цайвар өнгийн урт гонзгой элсэрхэг чулуу ашиглан үйлджээ. Уг эдлэл нь ташуу хугарсан байх ба урт нь 15,5 см, өргөн нь 8,6 см бол зузаан нь 6,7 см байна (зураг 6. 3).

Судалгааны хэлэлцүүлэг

Тус цуглуулгад үлдцийн төрлийн эдлэл 18 ш байх ба зургаа нь бэлдэц, арван хоёр нь үлдэц ажээ. Бэлдцийн гурав нь шаантган үлдэц хийхэд зориулагдсан бол нэг нь бичил цуулалтад зориулагдсан тайрдсан, үлдсэн хоёр нь бүрэн гүйцэд засагдаагүй байна. Нэг бэлдэц нь уртавтар ялтас салган авахад зориулагдсан үлдцийн бэлдэц боловч гүйцэд боловсруулалгүй орхижээ. Үүнтэй ихэд төстэй гүйцэд боловсруулагдсан үлдцийн бэлдэц Рашаан хадны суурингаас илэрсэн ба түүнийг мезолитын үе [Монголын чулуун., 2016: 202]-д холбон үзсэн байдаг. Үлдцүүд нь тайрдсан, шаантаг, цилиндр болон шовх хэлбэртэй хэмээн ангилагдана. Эдгээрээс хамгийн сонирхолтой нь урт ялтас цуулах зориулалттай шовх үлдэц юм. Цуулалтын гадаргуун бүх талаас урт ялтас цуулж авчээ. Ийм үлдэц манай орны нутаг дахь шинэ чулуун зэвсгийн үеийн бууц суурингаас төдий л олноор олдож байгаагүй болно. Үүнтэй ижил үлдэц Норовлин уулнаас түүвэр байдлаар олдож байжээ [Монгол-Японы., 2011: 28]. Багаж зэвсгийн цуглуулгыг зэв, ялтсан зэв, зуулга ир,

хусуур, чулуун сүх, хосолмол зэвсэг, холтослуур, цоолтуур, шөвөг, хутга, иртэй ялтас, самбар чулуу, нухуур чулуу зэрэг төрөл зүйлээс бүрдэнэ. Хусуур зэвсэг хамгийн олон байх бол эдгээрийн 16 нь төгсгөл хусуур юм. Төгсгөл хусуур зэвсгийн зургааг залтас ашиглан хийсэн бол үлдсэнийг нь ялтас, цуулдас ашиглан хийсэн байна. Үлдсэн нь төгсгөл болон хажуугийн, давхар иртэй, дугуй, ирмэгийн 2/3-ыг ирлэсэн, ирмэгийн 3/4-ийг ирлэсэн хусуур зэвсэг ажээ.

Шинэ чулуун зэвсгийн сууринд түгээмэл байх зэвсгийн нэг бол зэв юм. Зэв нь зориулалтын хувьд бүгд ижил боловч хэлбэр хийц, төрх байдлын хувьд харилцан адилгүй. Бидний цуглуулгад тэгш суурьтай гурвалжин зэв нэг бий. Ийм зэв Монгол орны шинэ чулуун зэвсгийн үед холбогдох дурсгалт газруудаас олноор илэрч олддог. Тэгш суурьтай гурвалжин болон навчин хэлбэрийн зэвийг НТӨ III мянган жилийн эхэн үе [Цэвээндорж нар., 2002: 71-72]-ээс хэрэглэж эхэлсэн хэмээн үздэг. Дараагийн нэг зэвсэг нь ялтсан зэв болно. Ийм зэвийг нэг талт сумны зэв, неолитын үзүүр мээ зэвсэг хэмээн нэрлэх явдал ч бий. Энэ зэвсгийн гол онцлог нь тэгш хэмт жижиг ялтасны нэг үзүүрийг гол төлөв ар талаас нь шовхолж хурц үзүүр гаргах явдал юм. Ялтсан зэв Сүхбаатар аймгийн нутгаас олдсон түүвэр цуглуулга [Дорж, 1971: 156], Дундговь аймгийн Бага газрын Чулуу [Цогтбаатар, Лхүндэв. 2010: 58], Баянхонгор аймгийн Чихэн агуйн нэгдүгээр давхарга [Деревянко и др., 1998: 148], Булган аймгийн нутаг Эгийн голын хөндийн Марзын хөтөл, Харуулын гозгор уулын 2-р булш [Идэрхангай нар., 2015: 5-22]-наас тус тус илэрч байжээ. Эдгээрээс ялтсан зэвний он цагийн хамаарлыг нарийвчлан тогтоосон Чихэн агуйн нэгдүгээр давхарга нь 8055±155 жил, харин Марзын хөтлийн булш нь 6500±30 жилийн өмнө холбогдоно. Энэ нь ялтсан зэвийг шинэ чулуун зэвсгийн хөгжингүй үед нэлээд урт удаан хугацааны турш хийж ашиглаж байсны баталгаа болж байна.

Багаж зэвсгийн цуглуулгад байгаа нэг сонирхолтой эдлэл бол сайтар засаж хийсэн хурц иртэй чулуун сүх юм. Өмнө нь Монгол нутгаас илэрч олдсон неолитын үед холбогдох сүхнүүдийг чулууны байгалийн хэлбэрийг чадамгай ашиглан хэрэглээний хэсгээс бусад гадаргууг гол төлөв зүлгэн өнгөлж хийсэн байдаг. Харин энэ сүхний хоёр хажуу ирмэгийг хоёр талаас нь солбин жигд цуулах замаар долгио бүхий хурц ирмэг гарган маш нямбай бэлтгэжээ. Хэлбэр, хэмжээний хувьд ижил төрлийн бусад сүхтэй ихэд ойролцоо болно. Ямартай ч энэ чулуун сүх нь шинэ чулуун зэвсгийн үед холбогдох нь тодорхой юм.

Өөр нэг сонирхолтой олдвор бол самбар болон нүдүүр чулуу юм. Самбар чулуу нь хугархай

боловч анхны хэлбэр төрх нь маш тодорхой мэдэгдэнэ. Нэг нь бараг бүтэн шахуу. Түүний нэг талын гадаргуу нь ихэд элэгдэж хотойжээ. Самбар чулууг элдэв ургамлын үр жимсийг бяцалж няцлах зэрэг олон зориулалтаар ашиглаж байсан хэмээн үздэг. Тэдгээрийг ихэнхдээ нарийн ширхэгтэй элсэн чулуугаар хийж буланг нь зүлгэн засаж мөлийлгөсөн байдаг. Самбар чулууны зөвхөн нэг хавтгай талыг бус эсрэг талыг ч ашигладаг байсан нь мэдэгддэг. Бүрэн гүйцэд засагдан хэрэглэгдэж байсан ул мөр бүхий самбар чулуу Сүхбаатар аймгийн Онгон элс [Дорж, 1971: 16], Сайнхарын гол [Далантай, 2014: 93], Зараа уул [Одсүрэн нар., 2015: 77], Дорнод аймгийн Овоот [Дорж, 1971: 36], Баруун Өлзийт [Монгол улсын., 2003: 90], Дулааны говь [Цэвээндорж, Хосбаяр. 1982: 26], Чандмань хар уул [Монголын чулуун., 2016: 274], Их Нарт [Scheider et al., 2015: 102-107], Өмнөговь аймгийн Баян заг [Fairservis, 1993: 32-38], Эргийн хоолой, Хоёр хайрхан, Төгрөг ширээт, Талингарын шал [Одсүрэн, 2018: 39-86] зэрэг Монгол орны говь, тал хээрийн бүс нутгаас гол төлөв илэрч олддог. Самбар чулуутай хамт түгээмэл олддог нэг эдлэл бол нүдүүр юм. Нүдүүрийг самбар чулууны адил элсэн чулуугаар хийжээ. Самбар болон нүдүүр чулуу нь Монгол орны шинэ чулуун зэвсгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох гол эдлэл болно. Монгол орноос илэрч олоод буй самбар чулууны хэлбэр хийц, хэмжээ зэрэгт оршин буй бүс нутгийн ялгаа байгаа нь мэдэгддэг.

Чулуун зэвсэг хийсэн түүхий эд. Дурсгалт газар нь Дорнод аймгийн нутаг дэвсгэрт хамаарах бөгөөд Дорнод Монголын галт уулын бүслүүрийн хойд хэсэгт оршдог. Монгол орны эрдэс чулуулгийн илэрц, тархалтын хувьд эндэхийн газрын гадаргуу нь гол төлөв пермийн болон мезозейн эриний галт уулын чулуулаг мөн дээд палеозойн боржин чулуудаас тогтжээ [Gereel et al., 2021: (eds) 337-338]. Эдгээрээс кварц, базальт, андезит, риолит төрөлд багтах чулуулаг нь галт уулын гаралтай бөгөөд бүтцийн хувьд нягт, хатуулаг сайтай тул чулуун зэвсэг хийхэд нэн тохиромжтойд тооцогддог. Халгайтын булангийн чулуун зэвсгийн олдворуудыг хийсэн түүхий эд нь дээрх төрөлд хамаарах бөгөөд бидний нэрлэж заншсанаар тунамал чулуулгийн төрөлд хамаарах цахиур болон мана гэх мэт эрдэс чулуулгууд юм. Ийм эрдэс чулуулагт хар, ногоон, цагаан, бор, шар, хүрэн зэрэг тод өнгө голлохоос гадна гадаргууд нь өнгөр тогтсон, завсрын болон судалтай гэх мэт олон өнгө хорших ажээ.

Эртний дархчууд өөрсдийн хэрэгцээт багаж зэвсгээ хийхдээ эрдэс чулуулгийг хэрхэн сонгож ашиглаж байсны нэг жишээ нь эндээс илэрч олдсон самбар болон нүдүүр чулуу хийсэн түүхий эд болно. Тэдгээрийг харилцан адилгүй ширхэгтэй

элсэн чулуугаар хийжээ. Элсэн чулуу нь хатуулаг сайтай хагалж цуулахад тохиромжтой биш боловч үрж, зүлгэж өөрсдийн хэрэгцээт аж ахуйн том хэмжээтэй эдлэл хийхэд ихэд хялбар байсан бололтой. Нөгөө талаар элсэн чулуу нь бусад эрдэс чулуулгийг бодвол хөнгөн тул зөөвөрлөхөд элдэв хүндрэлгүй байжээ.

Ваар савны хагархай. Уг дурсгалт газраас шавар ваарны хагархай олноор илэрч олддог. Эдгээрийг гол төлөв олон хагарч бутарсан жижиг хагархай, хэлтэрхий бүрдүүлж байна. Шавар ваарны үлдэгдлийн хадгалалтын байдал нь тухайн ил суурингийн онцлогоос ихээхэн хамаардаг. Бидэнд буй ваар савны хагархай цуглуулгаас харахад гадаргуу дээрх хээ дүрс, нимгэн зузааны хэмжээ, шатаалт, өнгө зэргээрээ харилцан адилгүй байгаагаас үзвэл, дөрвөөс таван төрлийн шавар ваар савны үлдэгдэл болох нь мэдэгдэнэ. Хэдийгээр нэг төрлийн ваарны хагархай олноор байв ч хоорондоо эвлэж нийлэх нь тун ховор. Цөөн тоотой байх ваарны амсар, хүзүү хийгээд ёроол хэсгийн үлдэгдэлд тулгуурлан ямархуу хэлбэр, хийцтэй сав байсныг төсөөлж болмоор санагдана. Гэвч юун түрүүнд эдгээр ваарны хагархайнууд хэдий үед холбогдохыг тогтоох нь чухал юм. Газарзүйн нэгэн бүсэд хамаарах, Монгол орны шинэ чулуун зэвсгийн үед холбогдох Тамсагбулаг, Шавартайн булаг, Зараа уул болон Говийн бүсийн ваарны хагархайн хээ дүрстэй харьцуулж үзэхэд ижилсэх зүйл тун бага байна. Тухайлбал, дээрх бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн үеийн ваар савыг сүлжмэл торны ормоор гарсан олон зэрэгцээ хонхор маягийн хээ, эгнэсэн ташуу зураасан болон хонхор хээ, зэрэгцээ, товгор, хөндлөн болон босоо шугаман, огтлолцсон хэлбэрийн зураасан болон наамал зэрэг олон төрөл хээгээр чимэглэдэг [Одсүрэн, 2020: 27-32] байсан нь тогтоогджээ. Нөгөө талаар бидний өгүүлэн буй ваарны хагархайд бүтэц найрлага болон он цаг тогтоох шинжилгээ хийгдээгүй, харьцуулан үзэх хэрэглэгдэхүүн дутмаг байна.

Судалгааны дүгнэлт

Тус дурсгалт газраас түүвэрлэн цуглуулсан чулуун зэвсгийн олдворуудын анхдагч цуулалт нь шаантган болон бичил үлдэц хийхэд зориулагдсан бэлдэц, тайрдсан үлдэц, шаантаг болон шовх үлдэц, цилиндр хэлбэрийн үлдцээр илэрхийлэгдэх ажээ. Багаж зэвсгийн ихэнх хувийг жижиг хэмжээтэй төрөл бүрийн хусуур зэвсэг бүрдүүлэх бол зэв, зуулга ир, ялтсан зэв, холтослуур, хосолмол зэвсэг, цоолтуур, шөвөг, ооль, хутга, чулуун сүх, иртэй ялтас, иртэй цуулдас ч тодорхой хувийг эзэлнэ. Үүнээс гадна Монгол орны неолитын хөгжлийг бүрэн төлөөлөхүйц самбар болон нүдүүр чулуу ч олдсон юм. Дурсгалт газрын чулуун зэвсгийн

анхдагч цуулалтын арга ажиллагаа, багаж зэвсгийн төрөл зүйл, овор хэмжээ болон зарим нэг олдворын харьцуулсан судалгаанд тулгуурлан шинэ чулуун зэвсгийн хөгжингүй үед холбогдоно хэмээн үзэж байна.

Халгайтын булангийн элсэрхэг хөрсөнд чулуун зэвсгээс гадна шил, шаазан, шавар, хүрэл, төмрөөр хийсэн археологийн олон үед хамаарах төрөл бүрийн эдлэл байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр үе үе ил гарах, дарагдан булагдах зэргээр хоорондоо холилдон оршиж байна. Энэ нь мөстлөгийн дараах үеэс ил усны дэргэдэх элсэрхэг газар нь хүний амьдралын үйл ажиллагаатай салшгүй холбоотой байсныг илтгэх ажээ. Газрын гадарга дээр ил орших олдвор бүхий дурсгалт газрууд нь томоохон голын хөндий, нууруудын ай сав, булаг шанд бүхий газарт олноор тохиолдох бөгөөд нэг томоохон төвлөрөл нь Монгол орны зүүн бүс нутаг юм. Ийм дурсгалт газраас шинэ эх хэрэглэгдэхүүн, баримт нотолгоо хэрхэн илэрч болохыг Майхант уулын дурсгалын олдвор хэрэглэгдэхүүнээр жишээлж болохоор байна. Цаашид олон үеийн дурсгал агуулсан түүвэр олдворт газарт археологийн судалгаа явуулах тохиромжтой арга зүй боловсруулж хэрэгжүүлэх нь илүү үр дүнд хүрч болохыг харуулж байгаа юм.

Талархал

Халгайтын булангийн чулуун зэвсгийн дурсгалын талаарх мэдээлийг өгч, түүвэр цуглуулга бүрдүүлэхэд туслалцаа үзүүлсэн ШУТИС-ийн БУХС-ийн багш, доктор (Ph.D), дэд профессор Л.Эрдэнэболд, олдворын гэрэл зургийг авсан судлаач Б.Лхагвасүрэн нарт гүн талархал илэрхийлье.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 02 сарын 28

Өгүүлэл засварласан: 2023 оны 04 сарын 03

Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Далантай, 2014 – С.Далантай. Сайнхарын голоос илэрсэн шинэ чулуун зэвсгийн үеийн суурин. //Археологийн судлал. Tomus XXXIV. Fasc.7. тал. 89-103.

Деревянко, Окладников. 1969 – А.П.Деревянко, А.П.Окладников. Древние культуры восточных районов МНР. (К итогам археологических исследований 1949 и 1967 гг.) // Советская археология. №4. Москва. стр. 141-156.

Деревянко и др., 1990 – А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин, Е.В.Девяткин, Е.М.Малаева. Каменный век Монголии: Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск. - 646 с.

Деревянко и др., 1998 – А.П.Деревянко, Дж.Олсен, Д.Цэвээндорж, В.Т.Петрин, А.Н.Зенин, А.И.Кривошапкин, С.В.Николаев, В.П.Мыльников, Р.У.Ривс, Б.Гунчинсүрэн, Я.Цэрэндагва. Археологические исследования Российскойско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1996 году. Новосибирск. - 344 с.

Дорж, 1969 – Д.Дорж. Дорнод Монголын неолитын үеийн булш сууц. //Шинжлэх Ухааны Академийн мэдээ. №3,

Дорж, 1971 – Д.Дорж. Неолит Восточной Монголии. Улаанбаатар. - 171 с.

Доржсүрэн, 1957 – Ц.Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсгийн үеийн судлалын байдал. - 10 т.

Идэрхангай нар., 2015 – Т.Идэрхангай, Э.Мижиддорж, С.Оргилбаяр, Б.Галбадрах, Д.Эрдэнэбаатар, Б.Өнөрбаяр. Эгийн голын шинэ чулуун зэвсгийн үеийн булшнууд. //Journal of the Archaeology, History and Culture. Volume 11 (10). тал. 5-22.

Монгол улсын., 2003 – Монгол улсын түүх. Тэргүүн боть. - 437 т.

Монголын чулуун., 2016 – Монголын чулуун зэвсэг. I Боть. - 288 т.

Монгол-Японы., 2011 – Монгол-Японы хамтарсан “Монгол хүн” төслийн хүрээнд Дорнод, Хэнтий аймгийн нутгаар хийсэн хайгуул судалгааны ажлын товч тайлан. Обата Хироки, Манабэ Аяа, Г.Лхүндэв, Ц.Болорбат, Л.Ишцэрэн. АХГБСХ.

Наваан нар., 2009 – Д.Наваан, Д.Түмэн, М.Эрдэнэ, Д.Хатанбаатар, М.Анхсанаа. “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэсэн археологийн судалгаа. //Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Volume 5. №1 (344) December 2009.

Одсүрэн, 2018 – Д.Одсүрэн. Арц Богдын нуруу орчмын шинэ чулуун зэвсгийн дурсгалууд. Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. - 186 т.

Одсүрэн, 2020 – Д.Одсүрэн. Монголын говь, хээрийн шинэ чулуун зэвсгийн үеийн ваарны хэлтэрхийд хийсэн судалгааны үр дүн. //Acta Historica. Tomus XXI. Fasc. 2. тал. 27-37.

Одсүрэн нар., 2015 – Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз. Зүүн Монголын нутагт хийсэн шинэ чулуун зэвсгийн судалгааны зарим үр дүн. // Археологийн судлал. Tomus XXXV. Fasc.5. тал. 72-96.

Одсүрэн нар., 2017 – Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Яанз, А.Розен. Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа төсөл: Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа ууланд хийсэн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. АХГБСХ.

Окладников, 1950 – А.П.Окладников. Неолит и бронзовый век Прибайкалья. МИА, №18, М-Л. - 199 с.

Совместный отчет, 1977 – Совместный отчет Монгольско-Советской историко-культурной экспедиции 1969-1975 гг. АХГБСХ.

Цогтбаатар, Лхүндэв. 2010 – Б.Цогтбаатар, Г.Лхүндэв. Чулуун зэвсгийн судалгаа. Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага Газрын Чулуу. //Археологийн судлал. (VII) XXVII боть. тал. 45-69.

Цэвээндорж, Хосбаяр. 1982 – Д.Цэвээндорж, П.Хосбаяр. Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан нь. //Археологийн судлал. Tomus X. Fasc.3. тал. 22-47.

Цэвээндорж нар., 1990 – Д.Цэвээндорж, Д.Баяр,

Г.Мэнэс, Л.Билэгт, З.Батсайхан. 1990 – онд Чингис хааны булшийг хайх “Гурван гол” Монгол-Японы хамтарсан төслийн хүрээнд явуулсан археологийн хайгуулын тайлан. АХГБСХ.

Цэвээндорж нар., 2002 – Д.Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг. Монголын археологи. - 257 х.

Цэгмид, 1969 – Ш.Цэгмид. Монгол орны физик газар зүй. - 405 х.


Fairservis, 1993 – W.A.Fairserves. The Archaeology of the Southern Gobi, Mongolia. Durham: Carolina Academic Press.

Gerel et al., 2021 (eds) – Ochir Gerel, Franco Pirajno, Bayaraa Batkhishig, Jaroslav Dostal. Mineral resources of Mongolia. Springer Nature Singapore Pte Ltd. Volume 19. - 461 pp.


Scheider et al., 2015 – J.S.Scheider, Ya.Tserendagva, T.C.Hart, A.Rosen and A.Spiro. Mongolian Neolithic ground stone tools from the northern edge of the Cobi desert. //Studia Arcaeologica. Ulaanbaatar. Tom. XXXV. Fasc. 6. тал. 97-115.




Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Зураг 1. Хавцгайтын булан




Зураг 2. Шаантган үлдцийн бэлдэц – 1, 3, 5; тайрдсан үлдцийн бэлдэц – 4;
цуулалтын оромтой хагархай – 2; бэлдэц – 6.




Зураг 3. Шовх үлдэц – 1, 10, 11; тайрдсан хэв шинжийн үлдэц – 2, 5, 8, 9;
цилиндр хэлбэрийн үлдэц – 3; шаантаг хэлбэрийн үлдэц – 4, 6; бичил үлдэц – 7.



Зураг 4. Зэв – 1; ялтсан зэв – 2, 3, 4; зуулга ир – 5, 6, 7; хосолмол зэвсэг – 8, 9, 10; хянгар – 12; цоолтуур – 11, 13; шөвөг – 14; ооль – 15; хутга – 16; чулуун сүх – 17, 20; холтослуур – 18, 19; иртэй ялтас – 21.



Зураг 5. Төгсгөл хусуур – 1, 4, 5, 7, 8, 11, 12, 13, 14, 15, 18; төгсгөл болон хажуугийн хусуур – 3, 6, 9; ирмэгийн 2/3-ийг ирлэсэн хусуур – 16; ирмэгийн 3/4-ийг ирлэсэн хусуур – 2, 10, 20; давхар иртэй хусуур – 17; дугуй хусуур – 19; иртэй ялтас – 21, 22, 23, 25; иртэй цуулдас – 24.



Зураг 6. Самбар чулуу – 1, 2; нүдүүр чулуу – 3.